



"АР СИ ЭС СИ" ХХК

УЛААНБААТАР ХОТ-16081 БАЯНГОЛ ДҮҮРЭГ,
5-Р ХОРОО, 10-Р ХОРООЛОЛ,

ЗУРГИЙН ШИФР 02/2021

**Говь-Алтай аймгийн Жаргалан сумын "Завхан" гол дээр
баригдах төмөрбетон гүүрийн зураг төслийн тайлбар бичиг**



Улаанбаатар хот 2021он

Захиалагч:



БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ

Гүйцэтгэгч:



АВТО ЗАМ, ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ,
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
"АР СИ ЭС СИ" ХХК

ЗАВХАН ГОЛ ДЭЭР БАРИГДАХ ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

ТАЙЛБАР БИЧИГ

Гүйцэтгэх захирагч



Д.Нямдаваа

Инженер:

Б.Ардах

Улаанбаатар хот. 2021 он

БҮЛЭГ-1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжинд үндэслэн Барилга хот, байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн болон Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдтой 2021 оны 06 сарын 11-ны өдөр №2021/140 тоот "ЗАВХАН ГОЛ ДЭЭР БАРИГДАХ ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ" зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Уг ажлын хүрээнд төмөрбетон гүүрийн зураг төслийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 03 сарын 10-ны өдрийн №11/21 тоотгоор баталсан зураг төслийн даалгаврын дагуу гүйцэтгэсэн болно.

1.1 Үндэслэл

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралт
- БХБСайдын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 32 дугаар тушаал
- "Ачаалал ба үйлчлэл" БНБД 2.01.07-90
- "Автозам гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02
- "Автозам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016
- "Авто замын гүүр ба хоолой БНБД 32-02-12
- Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4957:2014,
- Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4759:2014
- "Газар хөдлөлтийн дүс нутагт барилга байгууламж төлөвлөх "БНБД 22.01.01.2006 болон бусад холбогдох норм дүрмүүдийг үндэслэх.
- "Цутгамал бетон, төмөрбетон бүтээц" БНБД 3.03.01-88
- "Чгсармал төмөрбетон бүтээц" БНБД 3.03.02-90
- MNS5207-2011


1.2 Ажлын бүтэц бүрэлдэхүүн

- ГҮҮР, АВТОЗАМЫН АЖЛЫН ЗУРАГ
- ТАЙЛБАР БИЧИГ
- ТЕХНИКИЙН ШААРДЛАГА
- БАЙРЗҮЙН ЗУРАГЛАЛЫН ТАЙЛАН
- ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН ТАЙЛАН
- ГҮҮР, АВТОЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН ТӨСӨВ
- УС ЗҮЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
- БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ
- АРХЕОЛОГИ ТАНДАЛТЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1.3 Төслийн товч танилцуулга:

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Завхан гол дээр баригдах төмөр бетон гүүрийн барилгын зураг төсөл

Байршил: Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Завхан гол дээр



Зураг-1 Төлөвлөж буй гүүрийн байршил

1.4 Төслийг боловсруулахад оролцсон байгууллага, хүмүүс:

- "Эл Эм Ланд" ХХК, (Инженер-геологийн судалгаа хийж тайлан гаргасан)
- "Эл Эм Ланд" ХХК, Геодези, (Байр зүйн судалгаа хийж тайлан гаргасан)
- Ус зүйч мэргэшсэн инженер Х.Бадарч, (Ус зүйн тооцооны тайлан)
- "Сату" ХХК, (Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ гаргасан)
- Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Доктор Т.Батбаяр, (Археологийн хайгуул судалгаа)

1.5 Төслийн техникийн үзүүлэлтүүд

Хүснэгт -1.1

| № | Техникийн үзүүлэлт | ЗЗБНД 22-004 -2016 |
|---|-------------------------|---------------------|
| 1 | Замын зэрэг | Орон нутгийн зам 3А |
| 2 | Тооцоот хурд, км/цаг | 50 |
| 3 | Зорчих хэсгийн өргөн, м | 6,0 |

| | | |
|---|--------------------|------|
| 4 | Хөвөөний өргөн, м | 1,0 |
| 5 | Далангийн өргөн, м | 8,0 |
| 6 | Замын нийт урт, м | 3204 |

БҮЛЭГ-2. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Гүүрийн байршил

Авто замын төмөрбетон гүүрэн байгууламж барихаар төлөвлөж буй судалгааны талбай нь газарзүйн байрлалын хувьд Алтайн ар говийн муж, Их нууруудын хотгорын тойрогт багтаж далайн түвшнээс дээш 174м-ийн өндөрт, ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсацгүй голуудын савд, засаг захиргааны хувьд говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутагт оршино.



Зураг 2. Гүүрийн байршлын тойм зураг

2.2 Чур амьсгалын нөхцөл

Говь-Алтай аймгийн дийлэнхи нутаг уур амьсгалын мужлалаар гандуу дулаан зунтай, хахир болон хахирдуу өвөлтэй мужид хамрагдах болон Монгол Алтай болон Говийн Алтайн нурууны гол нурууд чийглэгдүү, сэрүүвтэр зунтай, хахир өвөлтэй мужид, Их Нууруудын хотгор, Нууруудын хөндийд хамрагдах зурвас нутгууд хуурай сэрүүвтэр зунтай хахир болон хахирдуу өвөлтэй мужуудад хамрагдана. Тус аймгийн өмнөд хилээр хүрээлэн тогтсон уул нуруу цөөн дэсрэг уулс цав толгод дүхий талархаг гадаргатай учраас дулаан бүсийн хуурай халуун агаар өмнө зүгээс чөлөөтэй нэвтрэн орж ирдэг нь дийлэнхи нутгаар зун дулаан, гандуу уур амьсгал ноёлох гол хүчин зүйл болно. Нөгөө талаас дэвсгэр гадарга ургамал нөмрөг багатай, элс, чулуурхаг гадарга ихтэй тул нарны элчинд хэт халж агаарын температурыг ихэсгэж ууршилтыг нэмэгдүүлнэ. Нутгийн баруун болон хойд зүгт хүрээлэн

тогтсон өндөр уулс нь хур тунадасны гол замналыг хааж тогтсон байдаг нь энд ерөнхийдөө цөлийн мэт уур амьсгалын нөхцөл бүрэлдэх гол хүчин зүйл болно.

2.3 Агаарын температур

Өвөл нь ууландаа $-17-19^{\circ}\text{C}$, хөндий, хотгор, говь нутгаар $-20-23^{\circ}\text{C}$ хүрч хүйтэрнэ. Хамгийн хүйтэн 1 дүгээр сард ууландаа $-40-45^{\circ}\text{C}$, хөндий хонхор газарт $-45-50^{\circ}\text{C}$ хүрч хүйтэрнэ. Зуны улиралд ууланд $8-15^{\circ}\text{C}$, хөндий говь, хотгортоо $+20-24^{\circ}\text{C}$ хүрч халдаг. Хамгийн халуун 7 сард 2000м -ээс дээш өндөрт $20-30^{\circ}\text{C}$, нам хотгор говьдоо $30-35^{\circ}\text{C}$ хүрдэг. Зарим үед нам хотгор хөрсний гадаргад $65-70^{\circ}\text{C}$ хүрч хална. Говь цөлийн бүсэд намар хожуу хүйтэрч, хавар эрт 3 дугаар сарын 20-доор дулаарч байхад өндөр уулын бүсэд эрт хүйтэрч, хавар 5 дугаар сарын эхээр дулаарах тул ууландаа жилийн $235-260$ хоног, говьдоо $180-220$ хоног хүйтэн байна. Харин 10°C -ээс дээших идэвхитэй температурын нийлбэр $1500-2000\text{м}$ хүртэлх өндөрт $1100-1400^{\circ}\text{C}$ байх бөгөөд 1000м хүртэлх өндөрлөг нутагт $+28^{\circ}\text{C}$ -ээс дээш дулаан байна.

2.4 Хөрсний температур

Бүс нутгаар хөрсний гадаргын температурын олон жилийн дундаж температур 0.3°C байх ба агаарын температурын жилийн явцтай нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн (үнэмлэхүй бага температур $-50-51^{\circ}\text{C}$), 7 дугаар сард хамгийн дулаан (үнэмлэхүй их температур $+62-67^{\circ}\text{C}$) байна. Хөрсний гүнд улирлын хөлдөлтөөр $3,2\text{м}$ хүрч хөлдөх ба хөрсний гүнд цэвдэггүй. Хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн нь шавар, шавранцар хөрсөнд $2,2\text{м}$, элсэнцэр, жижиг ширхэгтэй элсэн хөрсөнд $2,7\text{м}$, том ширхэг элсэн хөрсөнд $2,9\text{м}$ том хэмхдэст хөрсөнд $3,2\text{м}$ тус тус байна.

2.5 Чийгшил ба тунадас

Говь-Алтай аймаг нь далай тэнгисээс алслагдсан, эргэн тойрон өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, агаар хуурай, хур тунадас бага, жилийн температурын зөрүү ихтэй эх газрын эрс тэс уур амьсгалтай, хуурайдуу нутаг юм. Агаар хуурай учраас жилийн дулааны улиралд чийгшил нийт нутагт $50-60\%$, үүнээс говьд $30-50\%$ байдгаас үзэхэд агаар нэлээд хуурай, агаарын харьцангуй чийг ууландаа $9-10\%$, говьд $3-4$ хувьд хүрч дуурна. Агаарын хуурайшилтаас шалтгаалан хур тунадасны хэмжээ нийтдээ бага, далайн түвшнээс дээш 2500м газарт 260мм , 2000м -ийн өндөрт 180мм , харийн $1000-1500\text{м}$ өндөрт $50-80\text{мм}$ хур тунадас дулааны улиралд унадаг. Чулархаг нутагт цас эрт ордог бөгөөд өндөр уулын бүсэд намрын анхны цас 8 дугаар сарын эхээр, хаврын сүүлчийн цас 6 дугаар сарын эхний 10 хоногт ордог. Энд жилийн $188-200$ хоногцоо цаасан дүрхүүлтэй байна. Хээр, говь-цөлийн бүсэд цасан дүрхүүл бараг тогтдоггүй, тогтсон ч $24-50$ хоногцоос үл хэтэрнэ. Алтайн уулс, түүний орчмоор цасан дүрхүүл $5-10\text{см}$, бүсэд нутгаар 5см -ээс ихгүй зузаантай байдаг. Мөн цасан шуурга шуурах тохиолдол цөөнгүй, ууландаа цасан шуургатай өдрийн тоо $15-23$, говь хөндийд $5-6$ хоног байдаг.

Уг бүс нутагт олон жилийн дундаж байдлаар $74-90\text{мм}$ тунадас унах ба түүний 85 орчим хувь нь зөвхөн дулааны улиралд буюу $5-9$ дүгээр саруудад ордог байна.

2.6 Салхи

Энэ орчимд баруун өмнө, баруун хойт ба хойд зүгийн салхи зонхилох бөгөөд салхийн хурд олон жилийн дунджаар $2,3-2\text{м/с}$ байх ба олон жилийн ажиглалтаас үзэхэд салхины дээд хэмжээ 20м/с хэрч байжээ. Тус бүс нутагт 15м/с -ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо харьцангуй бага байдаг байна. 100 жилд тохиолдож болох салхины хурдны дээд хэмжээ 42м/с байна.

2.7 Авто замын уур амьсгалын нөхцөл

Судалгааны район нь хуурай хээрийн, IIВ уур амьсгалын бүсэд хамаарагдах бөгөөд автозамын бүсийн уур амьсгалын геотехникийн зарим үзүүлэлтүүдийг АЗУАГН.01.01-2004 норм, дүрмээр өглөө.

Бүсийн тодорхойлолт

Хүснэгт №1

| Бүсийн дугаар, нэр | Дэд бүсийн индекс | Бүсийн товч тодорхойлолт | Уур амьсгалын болон хөрсний нөхцөл |
|---|---|---|--|
| II. Автозамын уур амьсгалын хээрийн бүс | IIВ. Чулын завсар хоорондын тал хээрийн дэд бүс | - Автозамын уур амьсгалын хуурай-хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр хүтэн дэсрэг уулт хээр, хээр талын хахирлаг дэд бүс. | - Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог болон ховор алаг тархсан, улирлын хөлдөлт-гэсэлттэй, хүйтний овойлттой болон суумтгай лёсс маягийн хурдас элдэг тархсан. - Тал хээрийн дэд бүс нь улирлын гүн хөлдөлттэй овойлт болон суулт үүсгэнэ. Цас нимгэн, хахир өвөлтэй. |

Автозамын уур амьсгалын бүсүүдийн улирлын үргэлжлэх хугацаа*

Хүснэгт №2

| Бүс | Дэд бүс | Өвөл | | | Хавар | | Зун | | Намар |
|-----|---------|----------------|---------------------|-----------------|---------------|-----------------|------------------|-----------------|-----------------|
| | | Эхлэх | Дуусах | Үргэлжлэх хоног | Дуусах | Үргэлжлэх хоног | Дуусах | Үргэлжлэх хоног | Үргэлжлэх хоног |
| II | IIВ | 1-9.XI 5.XI | 15-24.III 19.III | 126-143 134 | 6-12.V 9.V | 45-52 48 | 8-19.IX 13.IX | 112-156 129 | 44-54 49 |

Тайлбар: *өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэх намрын дуусах хугацаа болно.

Хөрс агаарын температурын (°C) үзүүлэлт

Хүснэгт №3

| Бүс | Дэд бүс | Хөрсний гадаргын температур, °C | | | | Агаарын орчны дундаж температур, °C | | |
|-----|---------|---------------------------------|----------------|----------------|--------------------|-------------------------------------|----------------------|----------------------|
| | | Олон жилийн дундаж | Хамгийн халуун | Хамгийн хүйтэн | 0° нэвчих гүн, см* | Олон жилийн дундаж | Хамгийн хүйтэн сарын | Хамгийн дулаан сарын |
| II | IIВ | +0...+3 | 60-65 | -41...-45 | 250-350 | -2...+2 | -20...-25 | 15...20 |

Тайлбар: *0° нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд доод хязгаарыг авав.

Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Хүснэгт №4

| Бүс | Дэд дүс | Хөлдөлт | | | Гэсэлт | | |
|-----|------------|-----------------|----------------------|----------------|------------------------|---------------------|-------------|
| | | эхлэх | дуусах | хоног | эхлэх | дуусах | хоног |
| II | IIВ | 20-30.X 25.X | 15.III-30.IV 5.IV | 120-195 160 | 15.III-10.IV 25.III | 15.IV-31.V 23.IV | 20-50 35 |

Автозамын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой

болон тохиромжгүй улирлын үеүүд

Хүснэгт №5

| Бүс | Дэд дүс | Дулааны улирал* | | | Хүйтний улирал |
|-----|------------|-----------------|--------|-------|----------------|
| | | эхлэх | дуусах | хоног | хоног |
| II | IIВ | 10.IV | 19.X | 192 | 173 |

Тайлбар: *автозамын үйлдвэрлэлийн хүйтэн улирлын эх нь дулаан улирлын төгсгөл, хүйтэн

улирлын төгсгөл нь дулаан улирлын эх болдог.

Автозамын уур амьсгалын жилийн 4 улиралын салхины

хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Хүснэгт №6

| Бүс | Дэд дүс | Салхины хурд, м/с | | | | Даралт, мм Н _г баганын өндөрөөр | Харьцангуй чийгшил, % |
|-----|------------|-------------------|-------|-----|---------|--|-----------------------------|
| | | өвөл | хавар | зун | намар | | |
| II | IIВ | 1.6-4.0 | 3-7 | 2-4 | 2.5-5.5 | 600-650 | 50-60 |

Автозамын уур амьсгалын дүс дахь хур тунадасны хэмжээ, мм

Хүснэгт №7

| Бүс | Дэд дүс | Хур тунадасны нийлбэр, мм | | | | | | | |
|-----|------------|---------------------------|-------|---------|-------|---------|---|-----|---|
| | | өвөл | хавар | зун | намар | жил | 1 хоногт орох борооны хангамж, мм | | Борооны хамгийн их орох эрчим, мм/мин |
| | | | | | | | 2% | 1% | |
| II | IIВ | 3-10 | 15-30 | 150-200 | 20-35 | 220-250 | 80 | 104 | 1-150 |

Автозамын уур амьсгалын бүсийн нарны цацраг,
нарны гийгүүлэлийн хэмжээ

Хүснэгт №8

| Бүс | Дэд бүс | Нарны цацраг, Мд/м ² | | | Нарны гийгүүлэл, цаг | | | | |
|-----|---------|---------------------------------|-----------|-----------|----------------------|---------|---------|-------------------|------------------|
| | | нийлбэр | шууд | шингэсэн | жил | XII | VI | XII сарын 1 өдөрт | VI сарын 1 өдөрт |
| II | IIВ | 4500-5300 | 2700-3200 | 3500-3700 | 2700-3300 | 150-200 | 270-300 | 6-7 | 9-10 |

Автозамын техник ашиглалтын түвшинд сөргөөр нөлөөлж болох уур амьсгалын үзэгдлүүд, тэдгээрийн үйлчлэл, мөчлөгийн хэмжээ

Хүснэгт №9

| Бүс | Дэд бүс | Техникийн уур амьсгалын хахир хатуу, балл | | Уур амьсгалын н хахиршил | Нийт аянзгын үйлчлэл | | 1 аянзгын | | | |
|-----|---------|---|----------------|-------------------------------------|------------------------|-----------------|--------------------------------|---|----------|---------|
| | | хүйтний | дулааны | | Өдрийн тоо | Үргэлжлэл, цаг | Үргэлжлэл, минут | 1км ² талбайн ниргэлтийн тоо | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | | |
| II | IIВ | 50-60 | 20-25 | 3-3.5 | 25-35 | 4.0-4.5 | 80-110 | 5-6 | | |
| | | Нойтон цастай | | Хялмаатай | | Мөстлөгтэй | | | | |
| | | Өдрийн тоо | Үргэлжлэх, цаг | Өдрийн тоо | Үргэлжлэх, цаг | Өдрийн тоо | Зузаан, мм 10 жилд | Зузаан, мм 5 жилд | | |
| | | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | | |
| II | IIВ | 3-5 | 3-4 | 3-5 | 10-13 | 1-2 | 10 | 5 | | |
| | | Ачаалал, кг/м ² | | Металлын зэврэлт болох хугацаа, цаг | Тохиромжгүй өдрийн тоо | | | | | |
| | | Салхины | Цасны | | Халуун | Цасан шуургатай | Шороон шуургатай | Хүчтэй салхитай | Бороотой | Цас-тай |
| | | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 |
| II | IIВ | 40-55 | 40-60 | 1500-2000 | 25-40 | 3-4 | 10-30 | 8-15 | 40-60 | 20-35 |
| | | Халууны нөөц, нийлбэр | | Хүйтний нөөц, нийлбэр °C | | | Хүйтний үргэлжлэх хугацаа, цаг | | | |
| | | +20 | +25 | -20 | -25 | -30 | -20°C | -30°C | -40°C | |

| | | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 |
|----|-----|--|-----------|-----------|----------------------------|---|-------------|--|-----------|
| II | IIВ | 80-2000 | 1000-1300 | -300-2000 | -900-1000 | -1000-1500 | 1300-1600 | 200-400 | 1-5 |
| | | Тогтвортой цасан дүрхүүл | | | | | | Тогтвортой хүйтэн үед цочир дулааралттай, замд хальтиргаа гулгаатай байх хугацаа | |
| | | Тогтох | ханзрах | Хоног | Хамгийн зузааны дундаж, см | Нягт, г/см ³ | Нөөц ус, мм | Эхлэх | Дуусах |
| | | 34 | 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 |
| II | IIВ | 20.XI-1.XII | 10-20.III | 60-120 | 10-15 | 0.20-0.25 | 10-20 | 1.XII | 15.III |
| | | Хүйтэн улирлын жавар хавсаргатай (>8м/с), хахир үе | | | | Хөрсний 0-50см гүний чийгшлийн нөөц, мм | | | |
| | | Өдрийн тоо | | Цаг | | Хавар | | Намар | |
| | | 42 | | 43 | | 44 | | 45 | |
| II | IIВ | 100-125 | | 500-650 | | 10-30 | | 30-50 | |

Автозамын уур амьсгалын бүсэд халуун асфальт бетон
хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Хүснэгт №10

| Бүс | Дэд бүс | Асфальт болон замын хучилт | | |
|-----|---------|----------------------------|------------------------|-----------------|
| | | Эхлэх | Дуусгах | Хоног |
| II | IIВ | 18.IV-16.V (2.V) | 15.III-19.IX (1.IX) | 91-154 (122) |

Автозамын уур амьсгалын бүсэд хүйтэн, бүлээн асфальт
бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа

Хүснэгт №11

| Бүс | Дэд бүс | Асфальт болон замын хучилт | | |
|-----|---------|----------------------------|-----------------------|------------------|
| | | Эхлэх | Дуусгах | Хоног |
| II | IIВ | 3-30.III (16.III) | 30.X-4.XII (15.XI) | 220-278 (250) |

Автозамын шороон далангийн хөрсний

чийг-дулааны горимын мөчлөгүүд

Хүснэгт №12

| Бүс | Дэд бүс | Замын даланд намар чийг хуримтлагдах | | | Даланд өвлийн чийг хуримтлагдах | | Замын ул хөрс гэсэж чийгээр ханах | | Замын далан хуурайших |
|-----|---------|--------------------------------------|--------|-------|---------------------------------|-------|-----------------------------------|-------|-----------------------|
| | | Эхлэх | Дуусах | Хоног | Дуусах | Хоног | Дуусах | Хоног | Хоног |
| II | IIВ | 10.X | 15.XI | 36 | 1.IV | 137 | 20.V | 49 | 143 |

Тайлбар: Даланд өвлийн чийг хуримтлагдах эхлэх хугацаа нь намрын чийг хуримтлагдах дуусах, замын хөлдүү гэсэж чийг нэмэгдэхийн эхлэл нь өвлийн чийг хуримтлагдаж дуусах, замын далан хуурайших үеийн эхлэл нь хөрс гэсэж дуусах, төгсгөл нь намар чийгшил хуримтлагдах эхлэх хугацаа тус тус болно.

2.8 Геологийн тогтоц

Судалгааны район нь Өмнөд Монголын тогтолцооны герцины атриат бүтцийн хүрээнд байрлана. Энэхүү атриат бүтцийн зүсэлтэнд ногоон чулуун, порфиритийн хэлбэршил хурдас чулуулаг өргөн хөгжсөн байна. Говь-Алтайн нурууны дагууд эрт төрмөлийн хувирмал чулуун давхаргадасаас тогтсон бүтцүүд илэрнэ. Карбон ба пермийн тэнгисийн болон галт уулын этгүн гарлын зузаалаг, пермийн настай тэнгисийн ба эх газрын моласс хурдас нь томоохон ховдлууд бүтцүүдийг дүүргэсэн байна. Томоохон хотгор, хотос буурцгуудад голчлон цэрд, палеоген ба неогены улаан эрээн хурдсаар дүүрсэн байна. Дөрөвдөгчийн настай хошуу туудас, нуур, хагшаас болон салхин гаралтай хурдас өргөн тархсан байна.

Гүүрийн судалгааны зурвас талбайд дор саарал өнгөтэй, ургамлын үндэс бүхий өнгөн хөрсний доороос Дээд ба Орчин үеийн Дөрөвдөгчийн галавын настай, Аллюви-пролювийн /ар Q_{III-IV}/ гаралтай, цайвар улаан, дор саарал, саарал өнгөтэй, бул чулуутай, тоосорхог элс, сайрга бага зэрэг агуулсан дундаас том ширхэгтэй элс, сайргархаг элс, сайрга агуулсан шавранцар, шавар ул хөрсүүд илэрсэн бөгөөд тархалт зузааныг зүсэлтээр зурж үзүүлээ. /Хавсралт зураг-3/

2.9 Геоморфологийн хэв шинж ба физик-геологийн үзэгдэл үйл явц

Судалгааны зурвас талбай нь геоморфологийнхоо хувьд Говь-Алтайн мужид, Завхан голын татамд, элэгдэл зөөгдлийн хэв шинжит гадаргууд хамаарагдах бөгөөд баруун урдаас зүүн хойшоо намссан, үл ялиг хэвгийг тогтоцтой, гадаргуугийн үнэмлэхүй өндөржилт нь Завхан голын гүүр, замын далан – 1475.989-1478.304 метр, өндөржилтийн зөрүү 2.315 метр, Дунд голын гүүр – 1473.150-1473.860 метр, өндөржилтийн зөрүү 0.710 метр, Нарийн голын гүүр – 1471.370-1471.540 метр, өндөржилтийн зөрүү 0.170 метр, Их голын гүүр – 1465.840-1466.300 метр, өндөржилтийн зөрүү 0.460 метр байна.

Завхан гол, Дунд гол, Нарийн гол, Их голын эрэг дагууд, усны хүчтэй урсгал болон хаврын шар усны үерийн улмаас эргээ идэх буюу эррозийн үйл ажиллагаа идэвхтэй явагдана.

2.10 Гидрогеологийн нөхцөл

Судалгааны зурвас талбайд 6.0-15.0м хүртэл гүн өрөмдөхөд ул хөрсний усны илэрсэн түвшин 1.2-2.0м, ул хөрсний усны хөөрч тогтсон түвшин 0.7-1.8м байна. /2021 оны 06-р сарын 04-14-ний өдрүүдийн байдлаар/ Хур бороо элбэгтэй улирал (7, 8, 9-р саруудад) болон хаврын шар усны үерээр ул хөрсний ус 1.5-2.0м хүртэл түр дээшилнэ.

Завхан гол, Дунд гол, Нарийн гол, Их голын усны шинжилгээний дүнг нэгтгэн доорхи хүснэгтэд харууллаа.

Хүснэгт №13

| № | Голын нэр | Cl ⁻ , мг-экв/л | SO ₄ ²⁻ , мг-экв/л | HCO ₃ ⁻ , мг-экв/л | Цахилгаан дамжуулалт, мS/см | Эрдэсжилт, мг/л | pH | Курловын томъёо |
|---|------------|----------------------------|--|--|-----------------------------|-----------------|------|---|
| 1 | Завхан гол | 0.50 | 0.73 | 2.00 | 303.0 | 224.4 | 5.97 | $M_{0.2} \frac{HCO_3^- 61.9 SO_4^{2-} 22.6 Cl 15.5}{Ca 46.4 Mg 37.1 Na 16.4}$ |
| 2 | Дунд гол | 0.26 | 0.39 | 2.40 | 270.0 | 228.8 | 6.24 | $M_{0.2} \frac{HCO_3^- 78.7 SO_4^{2-} 12.8}{Ca 52.5 Mg 32.8 Na 14.7}$ |
| 3 | Нарийн гол | 0.43 | 0.59 | 2.50 | 321.0 | 203.5 | 5.58 | $M_{0.2} \frac{HCO_3^- 71.0 SO_4^{2-} 16.8 Cl 12.2}{Mg 39.7 Ca 36.9 Na 23.3}$ |
| 4 | Их гол | 0.45 | 0.78 | 2.55 | 367.0 | 272.8 | 6.10 | $M_{0.3} \frac{HCO_3^- 67.5 SO_4^{2-} 20.6 Cl 11.9}{Ca 42.3 Mg 37.0 Na 20.6}$ |

Усны шинжилгээний дүнгээс харахад:

Завхан гол - тухайн уст цэгийн ус нь Гидрокарбонат-сульфат ангийн, кальци-магнийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, цэнгээг, зөөлөн ус болохын хамт дохирдолтыг тодорхойлогч нэгдлүүд үл мэдэг илэрсэн байна. Тухайн ус нь бетон болон металл эдлэлд идэмхий шинж чанар үзүүлэхээргүй байна.

Дунд гол - тухайн уст цэгийн ус нь Гидрокарбонат ангийн, кальци-магнийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, цэнгээг, зөөлөн ус болохын хамт дохирдолтыг тодорхойлогч нэгдлүүд илрээгүй байна. Тухайн ус нь бетон болон металл эдлэлд идэмхий шинж чанар үзүүлэхгүй.

Нарийн гол - тухайн уст цэгийн ус нь Гидрокарбонат ангийн, магни-кальцийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармагдуу орчинтой, цэнгээг, зөөлөн ус болохын хамт дохирдолтыг тодорхойлогч нэгдлүүд бараг илрээгүй байна. Тухайн ус нь бетон болон металл эдлэлд идэмхий шинж чанар үзүүлэхгүй.

Их гол - тухайн уст цэгийн ус нь Гидрокарбонат ангийн, кальци-магнийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, цэнгээг, зөөлөн ус болохын хамт дохирдолтыг тодорхойлогч нэгдлүүд илрээгүй байна. Тухайн ус нь бетон болон металл эдлэлд идэмхий шинж чанар үзүүлэхээргүй байна.

2.11 Геокриологийн нөхцөл

Судалгааны район нь олон жилийн цэвдэг хөрс тохиолдлын тархалттай бүслүүрт хамаарагдах бөгөөд судалгааны зурвас талбайд 6.0-15.0 метр гүн өрөмдөхөд олон жилийн цэвдэг хөрс илрээгүй. /2021 оны 06-р сарын 04-14-ний өдрүүдийн байдлаар/

БҮЛЭГ-3. ГҮҮР БОЛОН АВТО ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ

Төлөвлөж буй гүүрийн трассын байршил нь Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд багтах Хяргас нуур Завхан голын сав газарт Завхан голын татамд оршино. Замын трассыг захиалагчаас өгсөн даалгаврын дагуу сумын Засаг дарга, холбогдох мэргэжилтэн нарын хамтаар газар дээр нь замын трассын байрлалыг тогтоосон.



Зураг-3. Завхан голын ерөнхий харагдах байдал

Гүүрийн төлөвлөлт

- Гүүрийн ангилал: IV
- Хөдөлгөөний зурвасын тоо: 2
- Гүүрийн урт : L=181.15м
- Овор хэмжээ: Г-6.5
- Аюулгүйн зурвас П:1.0мх2
- Зорчих хэсэг, пв: 4.5м
- Гүүрийн нийт өргөн: 7.1м
- Дээд хэсгийн дүтээцийн байдал : Төмөр бетон
- Дагуу налуу : 0 %
- Хөндлөн налуу : 2 %

- Хучилтын дүтээц: Тортой бетон хучилт $h=0.125\text{м}$

Наамал ус тусгаарлагч үе $h=0.01\text{м}$


Тэгшилгээний үе бетон $h=0.065\text{--}0.0\text{м}$

- Дэвсгэр зураг : шулуун
- Алгаслал төрөл : Т хэлбэрийн 18у/м дам нуруу
- Дам нурууны өндөр: 1.20м
- Суурийн төрөл : Өрөмдмөл шонт суурь
- Суурийн төлөвлөлтийн тодорхойлолт: Өрөмдмөл шонт суурь
- Даацын арматурлалт : SD390
- Бусад арматурлалт : SD390, SD290
- Суурийн ул хөрсний өгөгдөл :

ИГЭ-1.Бор саарал, саарал өнгөтэй, Аллюви-пролювийн гаралтай, Орчин үе-Дээд Дөрөвдөгчийн настай, чийгтэйгээс усаар ханасан тоосорхог Элсэн ул хөрс $R_0=200\text{кПа}$

ИГЭ-2. Улаан хүрэн, цайвар шаргал өнгөтэй, Аллюви-пролювийн гаралтай, Орчин үе-Дээд Дөрөвдөгчийн настай, чийгтэйгээс усаар ханасан, сайргатай тоос агуулсан жигд Элсэн ул хөрс $R_0=400\text{кПа}$

- Тооцоот ачаалал: А14, НК80 ачаалалууд болон дүтээцийн тогтмол хувийн жин
- Газар хөдлөлтийн ачаалал: газар хөдлөлтийн 9₃ балл



Зураг-4. Гүүрийн ерөнхий байдал


БНД 32.02.12-ын 1.4-р заалтыг үндэслэн тогтвортой гольдрол бүхий хэсгээр усны урсгалд 90градус-ын өнцгөөр огтлолцсон.

БНД 32.02.12-ын 1.2-р заалтыг үндэслэн тооцоот үерлэлтийн хамгийн их зарцуулалтын хэтрэх магадлалыг 1%-иар тооцоонд авсан.

Ус зүйн тооцоо болон түүнд харгалзах усны түвшинг тодорхойлох зэргийг БНД 2.01.14-86-д тавигдсан шаардлагын дагуу гүйцэтгэсэн.

БНД 32.02.12-ын 1.55-р заалтаар дамжих хавтангийн урт 8м-ээс ихгүй байна. Энэ заалтыг үндэслэн дамжих хавтангийн урт нь 4.0м урттай бөгөөд захын тулгуурын ар хана дээр шууд тавигдахаар зураг төсөлд тусгав.

Гүүрийн төлөвлөлтийг Захиалагчаас өгсөн зургийн даалгаврын дагуу болон "АВТО ЗАМЫН ГҮҮР БА ХООЛОЙ ТӨСӨЛЛӨХ" БНД 32.02.12 -ийн дагуу тавигдах шаардлагыг бүрэн хангахаар зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэсэн болно.



Зураг-5. Гүүрийн хөндлөн огтлол

Зорчих хэсгийн овор хэмжээ нь БНД 32.02.12-ын 1-р хавсралтад заасныг үндэслэн Г6.5 байхаар тооцов.

Гүүрийн зорчих хэсгийн хөндлөн хэвгий 20 промилль байгаа ба нэг алгаслал дээр нийт 6 шр ус зайлуулах цорго байхаар тооцсон болно.

Алгаслал байгууламжид 18 м-ийн урттай Т хэлбэрийн дам нурууг ашиглахаар тооцсон. Алгаслал байгууламжийн бетон нь В40 ангийн бетон байна.

Захын тулгуур

Захын тулгуурын ростверк, өрөмдмөл шонт суурь, далавч, ар хана болон их диеийн бетон нь В30 байна. Харин тулгуурын насадокны бетон нь В40 байна. Хэрэглэгдэх арматур нь SD390 байхаар сонголт хийв.

Завсрын тулгуур

Завсрын тулгуурын ростверк, өрөмдмөл шонт суурь болон их диеийн бетон нь В30 байна. Харин тулгуурын ригелийн бетон нь В40 байна. Хэрэглэгдэх арматур нь SD390 байхаар сонголт хийв.

Завхан голын гольдрол тогтвортой дүс байдаг ба хаврын шар усны үер болон их урсацын үед гүүрийн тогтвортой байдлыг хангах, гүүрийн 2 талын автозамын даланг хамгаалах үүднээс ус залах далан болон эргийн дэхэлгээг төлөвлөсөн болно. Ус залах далан болон эргийн дэхэлгээг зургийн дагуу зайлшгүй хийж гүйцэтгэнэ.

Автозамын төлөвлөлт

Төлөвлөж дүү авто замын геометр онцлог шинжүүдийг төлөвлөхдөө зургийн даалгаврын дагуу Автозам төсөллөх ЗЗБНДД 22-004-2016-д тусгасан **Хөдөө орон нутгийн ЗА** замын ангилалын замын шалгуур үзүүлэлт баримталсан болно. Замын геометр төлөвлөлтийг ОХУ-ны IndorCAD Road9 программ хангамж ашиглан гүйцэтгэсэн. Төлөвлөж дүү автозамын трассын нийт урь 3240м орчим байна

Хэвтээ муруйн төлөвлөлт

Хөдөө орон нутгийн замын чиг, трассыг амьдралд хамгийн их нийцсэн байхаар төсөллөх бөгөөд аюулгүй байдал, нэвтрүүлэх чадвар, харагдах байдал дүүю гадаад үзэмжийн үзүүлэлтийг бүрэн дүүрэн хангахын тулд хэвтээ болон босоо төлөвлөлтүүд нэг нэгнээ нөхөн, хосолсон байх ёстой. Хэвтээ төлөвлөлтийг огцом өөрчлөхөөс зайлсхийх хэрэгтэй бөгөөд босоо муруйнууд нь тооцоом хурдыг хангахын зэрэгцээ үзэгдэх зайн шаардлага хангасан байна. Тооцоом хурд 50 км/цаг байхад үзэгдэх зайн хангагдах нөхцлийг баримтлан хэвтээ болон босоо муруйн төлөвлөлтийг гүйцэтгэсэн.

Босоо муруйн төлөвлөлт

Босоо муруйн радиусыг стандартын дагуу сонгож үзэгдэх зай, дагуу налууг стандартын хэм хэмжээнд нийцүүлэн дагуу төлөвлөлтийг хийлээ. Дагуу төлөвлөлтийн параметрүүдийг ажлын зурагт үзүүлсэн болно.

Тооцоом хурд


Авто замын геометр төсөллөлтийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор сонгосон хурдыг тооцоом хурд гэнэ. Хөдөөгийн гол замын хөдөлгөөний эрчим, зорчих зурвасын өргөн, зурвасын тоо газрын гадаргуугийн нөхцөл байдал, үзэгдэх зайн хангалтыг харгалзан 30-60км/цаг хурдтай байхаар тооцоолсон.

Хүснэгт-3.1 Хөдөө орон нутгийн замын тооцоом хурд

| Замын ангилал | Хөдөлгөөний байдал | Зурвасын тоо | Газрын гадаргуугийн байдал | | |
|---------------|------------------------|--------------|----------------------------|------------|----------|
| | | | Тал | Хэрчигдсэн | Чулархаг |
| ЗА | Хөдөө орон нутгийн зам | 1-2 | 60 | 50 | 30 |

Хөндлөн огтлол

"Авто зам төсөллөх" ЗЗБНДД22-004-2016 Бүлэг 11.9-т зааснаар хөндлөн огтлолын хэмжээсүүд дараах байдлаар өгөгдсөн байна.



Зураг-6. Нэг маягийн хөндлөн огтлол

Хайрган хучилттай замын өргөний хувьд дараах стандартуудыг сонгосон. Үүнд:

- Зорчих хэсгийн өргөн 6,0м
- Хөвөөний өргөн 1,0м
- Замын хөндлөн хэвгий 4%
- Замын нийт өргөн 8.0м

Хүснэгт-3.2 Авто зам болон гүүрийн трассын тэнхлэгийн координат

| РК+ | X, м | Y, м | Z, м |
|-----------|-------------|------------|----------|
| 0+000.000 | 5233386.651 | 719411.651 | 1478.304 |
| 0+020.000 | 5233400.612 | 719425.972 | 1478.297 |
| 0+040.000 | 5233414.572 | 719440.293 | 1478.29 |
| 0+060.000 | 5233428.533 | 719454.615 | 1478.283 |
| 0+080.000 | 5233442.493 | 719468.936 | 1478.276 |
| 0+100.000 | 5233456.454 | 719483.258 | 1478.27 |
| 0+120.000 | 5233470.414 | 719497.579 | 1478.263 |
| 0+140.000 | 5233484.375 | 719511.901 | 1478.256 |
| 0+160.000 | 5233498.335 | 719526.222 | 1478.249 |
| 0+180.000 | 5233512.296 | 719540.543 | 1478.242 |
| 0+200.000 | 5233526.257 | 719554.865 | 1478.235 |
| 0+220.000 | 5233540.217 | 719569.186 | 1478.228 |
| 0+240.000 | 5233554.178 | 719583.508 | 1478.221 |
| 0+260.000 | 5233568.138 | 719597.829 | 1478.214 |
| 0+280.000 | 5233582.099 | 719612.15 | 1478.207 |
